



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГУРВАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 01 өдөр

Дугаар А/24

Пионер толгой

“Аз жаргалтай эмэгтэйчүүд-2023” нэгдсэн
арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ний өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Олон улсын Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан сумын хэмжээнд “Аз жаргалтай эмэгтэйчүүд-2023” нэгдсэн арга хэмжээг 2023 оны 3 дугаар сарын 7-8-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2.“Аз жаргалтай эмэгтэйчүүд-2023” нэгдсэн арга хэмжээний хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

3.Арга хэмжээг хөтөлбөрийн дагуу чанартай зохион байгуулж, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог хангаж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Р.Гантулга), Эрүүл мэндийн төвийн дарга (Г.Сүхбаатар), Соёлын төвийн дарга (Б.Бадамцэцэг), багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4.Тус арга хэмжээг зохин байгуулахад шаардагдах 800,000 (найман зуун мянга) төгрөгийг сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс гарган зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Р.Гантулга), нягтлан бодогч (Б.Дэлгэрдалай) нарт зөвшөөрсүгэй.

ДАРГА  Б.ГАНТУЛГА



642201219